



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 14

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2009 онд ашиглалтанд орсон 40,954,500 /дөчин сая есөн зуун тавин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 49-97 ДУА улсын дугаартай Донг Пенг маркын автомашины худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая / төгрөгөөр тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.


Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр) -т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Тувааны нэрэмжит Нэгдсэн эмнэлэг (Х.Жаргал) -т даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 62 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

Тав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

480219033